

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

Соёл урлаг, Боловсролын чиглэлээр

Сүхбаатар аймгийн Засаг Даргын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/155 дугаар захирамжаар батлагдсан "УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ, УДМЫН САНГАА ХАМГААЛЪЯ" угийн бичиг хөтлөлтийн уралдааны шилдэг хөтөлсөн айл өрхийн төрөлд, 4-н өрхийг тусгайлан бэлтгэж, материалыг Сүхбаатар аймгийн нийгмийн бодлогын хэлстэст явуулсан. Цахим хандалт 50

Соёлын төвийн ажилчид "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд байгууллагынхаа өрөө тасалгааг хөшигжүүлж тохижуулав

"ЧИНГИС ХААНЫ ӨВ СОЁЛЫН ХҮРЭЭЛЭН " СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ"-тэй хамтран бэлтгэсэн "ХАТАГИНЫ ХАР СҮЛД " нэвтрүүлэгийг үзэгч олондоо хүргэв. Нэвтрүүлэгийн баг хамт олонтой бичлэг хийхэд хамтран ажиллав. Цахим хандалт-105

Соёлын яам, СУИС-тай хамтран зохион байгуулж буй "Соёлын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх цахим сургалтанд соёлын төвийн ажилчид хамрагдав. Тус сургалт нь 5 өдөр буюу 2021.11.08-ны өдрөөс 2021.11.12 хүртэл өглөөний 09:00 цагаас оройн 18:00 цаг хүртэл үргэлжилсэн бөгөөд "Соёл урлагийн менежмент","Орон нутаг ба соёлын өв", "Цахим уншлагын цахимын үйлчилгээ", "Хөгжмийн боловсролын арга зүй", "Бүжиг заах арга зүй" зэрэг 5 чиглэлийн дагуу зохион байгуулагдаж "Серфитикад" аа гардан авлаа.

Юниско-ийн Байгаль,соёлын хамгаалах сан,Соёлын өвийн төв, Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газартай хамтран зохион байгуулсан "ЭХ НУТАГ ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЬЕ" 2 жилийн хугацаатай тэргүүн туршлагын улсын уралдаанд 21 аймаг 360 сум оролцсноос Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын ДАРХАНХААН уул "Улсын хэмжээнд тахилгын шилдэг зан үйлтэй уул"-аар шалгарлаа.

Энэхүү уралдаанд Дарханхаан уулын судалгааны ажлаар оролцоход дэмжлэг туслалцаа үзүүлсэн аймгийн БСУГ-ын ахлах мэргэжилтэн Б.Золхүү, Сүхбаатар сумын Мөнхэрдэнэномун хан хийдийн тэргүүн лам Д.Доржпалам нар гүн туслалцаа үзүүлж хамтран ажиллаа

2021. 11,16-нд Аймгийн засаг дарга 2020-2024-оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан "Сумдын соёлын төвүүдийн номын сангуудыг номын сангийн нэгдсэн цогц Lib4U программ"-д холбох сургалт үйл ажиллагааг номын сангаас зохион байгуулсан.

Мөн аймгийн нийтийн ном сан " Монгол улсад орчин цагийн номын сан үүсэж хөгжсний 100" жилийн баярын арга хэмжээг нэгдсэн журмаар зохион байгуулав.. 100-н

жилийн ойд зориулан зохион байгуулсан Улсын шилдэг номын сан шалгаруулах уралдаанд СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН НОМ САН "МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ НОМЫН САН"-гаар шалгарлаа. Цахим хандалт-780

Эрүүл мэндийн чиглэлээр

Нийт үзлэг – 6045

Урьдчилан сэргийлэх үзлэг – 3520

Амбулаторийн үзлэг – 1473

Идэвхитэй **хяналт – 1307**

Гэрийн дуудлага – 560

Яаралтай түргэн тусламжийн дуудлага – 792

Алсын дуудлага - 457

Нийт хэвтэн эмчлүүлэгч – 505

Ор хоног – 4331

Нийт нас баралт – 16

Халдварт бус өвчлөл эрт илрүүлэг үзлэг – 3171

Артерийн гепиртензий – 1300/1177/90%

Чихрийн шижин – 1340/1257/93%

Хөхний өмөн – 650/511/94%

Умайн хүзүүний өмөн – 210/81/38,5%

Жирэмсний эрт хяналт - 53/43/81,1%

Төрсөн эх – 6

Гэрийн асаргаа сувилгаа – 75

Хэвтэн эмчлүүлэгчид сургалт – 444

Сургалт сурталчилгаа – цахим 13 төрлийн 3965 хүний хандалт

Гарын авлага – 7600 /Тоон үзүүлэлтийн өссөн дүнгээр үзүүлэв/

- 📌 Байгууллагын цахим хуудасаар дамжуулан 13 төрлийн мэдээлэл оруулсанаас авсан нийт хандалтын тоо 3965
- 📌 Дархлаажуулалтын 3-р тунг явц 2316/540/23,3% тай явагдаж байна. Багийн засаг дарга эмч нарын хамтарсан баг хөдөөгийн багуудад явуулаар ажиллаж байна.
- 📌 Ковид-19 халдварын нийт батлагдсан тохиолдол 641 үүнээс эдгэрсэн 634 байна.Одоо хяналтан байгаа 7 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна.Гэрээр эмчлэгдэж байгаа хүн байхгүй

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль эрх зүйн мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч

Х.Өлзийхутаг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/